



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/86

Халбан

Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Уранхайрхан багийн Ужиг, Тэлээгээс Халзаны ам хүртэлх газруудын ойн сангийн 221, 283 зэрэг хэсэглэлүүдийн ойн талбайд яacobсоны төөлүүрч эрвээхэй, өрөөсгөл хур эрвээхэй зэрэг ойн хөнөөлт шавж голомттой тархалт илэрч хортон шавжийн устгал тэмцлийн ажлыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 07 дугаар сарын 16-ны хугацаанд голомт бүхий газар хүн, мал, тэжээвэр амьтан нэвтрүүлэхгүй хорио цээр тогтоосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хорио цээр тогтоосон хугацаанд орчны бүсийн иргэдэд мэдээлж хяналт тавьж ажиллахыг Уранхайрхан багийн Засаг дарга (Д.Баясгалан), Байгаль хамгаалагч (Б.Дашренчин) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т даалгасугай.

ДАРГА



Н.АНХБАЯР